



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС

ТАНИЛЦУУЛГА

2018

Аж үйлдвэрийн үйлдвэрлэгчийн үнийн индексийн талаар танилцуулгатай холбоотой мэдээлэл ба санал хүсэлт байвал доорх хаяг болон веб сайтад хандана уу.

Хаяг: Засгийн газрын III байр,
Бага тойруу -44, Улаанбаатар -11
Монгол улс

Вэб хаяг: www.nso.mn, www.1212.mn

Утас: 1900-1212

Холбогдох мэргэжилтэн

Утас: 51-261561 /Г.Мөнх-Оргил/

Зөвлөмж

Энэхүү тайланд агуулагдсан гол мэдээллүүд Үндэсний статистикийн хорооны мэдээллийн санд байдаг бөгөөд хувь хүн, албан байгууллага ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүйгээр бүрэн ашиглаж болно.

Мэдээллийн эх үүсвэр

Энэхүү тайланд ашигласан өгөгдлүүд нь хамгийн сүүлийн үеийн тоон үзүүлэлтүүдийг тусгасан. Мэдээллийн эх үүсвэр нь аж ахуйн нэгж байгууллагаас цуглуулагдсан үнийн мэдээлэл юм.

Танилцуулгыг боловсруулсан:

ЭЗСГ-ын ҮА-ны статистикч

Г.Мөнх-Оргил

Танилцуулгыг хянасан:

ЭЗСГ-ын дарга

Э.Эрдэнэсан

ЭЗСГ-ын ҮА-ны ахлах статисткч

Д.Мөнхзул

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	4
ОРШИЛ.....	5
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ.....	6
I. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС	8
ХАВСРАЛТ.....	13
• Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, дэд салбараар, сараар	
• Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, өмнөх оны эцэстэй харьцуулснаар, дэд салбараар, сараар	
• Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, өмнөх сартай харьцуулснаар, дэд салбараар, сараар	
• Тооцооны арга зүй	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ҮҮИ	Үйлдвэрлэгчийн үнийн индекс
ҮСГ	Үндэсний Статистикийн Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ААНБ	Аж ахуй нэгж, байгууллага
ЭЗБТУАСА	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
ҮСҮҮИ	Үйлчилгээний салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс
АҮҮҮИ	Аж үйлдвэрийн үйлдвэрлэгчийн үнийн индекс

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, дэд салбараар, хувь.....	9
Хүснэгт 2. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийн дэд салбаруудын оролцооны түвшин, хувь.....	11
Хүснэгт 3. Аж үйлдвэрийн салбарын жин, дэд салбараар.....	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, 2015=100, сараар, дэд салбараар, хувь.....	8
Зураг 2. Уул уурхай олборлолтын дэд салбарын үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, сараар, бүлгээр, хувь.....	9
Зураг 3. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийн дэд салбаруудын оролцооны түвшин, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар.....	10
Зураг 4. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, өмнөх сартай харьцуулснаар, дэд салбараар, хувь, 2018 он.....	11
Зураг 5. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн өсөлт, хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, 2018 он.....	12

ОРШИЛ

Үйлдвэрлэгчийн үнийн индексийг /ҮҮИ/ тооцох гол зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг судлах явдал бөгөөд энэ индексийг тооцсоноор инфляцыг урьдчилан таамаглах, ДНБ-ийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэх, Засгийн газар болон бизнесийн байгууллагууд бизнесийн дүн шинжилгээ хийхэд болон төрөл бүрийн индексжүүлэлтэд ашиглана.

Үнийн индексийн тооцооны чанар нь бизнес регистрийн сан, судалгаанд хамрагдах салбаруудын мэдээллийн чанар, бүтээгдэхүүний нэр төрөл, үнийн үнэн зөв, бодит байдлаас шууд хамаарна.

Үндэсний Статистикийн Хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийг сар бүр цуглуулж, үнийн индексийг тооцон олон нийтийн хүртээл болгож байна.

Үйлчилгээний салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийг Үндэсний Статистикийн Газрын(хуучин нэрээр) даргын 2007 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/45 тоот тушаалаар баталсан “Үйлдвэрлэгчийн үнийн индекс тооцох аргачлал” - ын дагуу 2015 оны суурь, сагс, жинтэйгээр тооцож байна.

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Үндсэн үнэ – Үйлдвэрлэл, үйлчилгээний газар нь аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гаргасан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үнэд татаасыг оруулж тооцно.

Үйлдвэрлэгчийн үнэ – Үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг бараа, үйлчилгээний татварууд (нэмэгдэл өртгийн албан татвараас бусад) болон тээвэр, худалдааны нэмэгдлийг нэмж, татаасыг хасаж тооцсон үнийг ойлгоно.

Зах зээлийн буюу худалдан авагчийн үнэ – Үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдсэн өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг зах зээлийн буюу худалдан авагчийн үнэ гэж ойлгоно.

Үнийн индекс – Тодорхой цаг хугацаанд үнийн түвшний өөрчлөлтийг илэрхийлэх харьцангуй үзүүлэлтийг үнийн индекс гэнэ.

Үйлдвэрлэгчийн үнийн индекс – Тухайн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Хувийн индекс – Юмс үзэгдлийн зөвхөн тухайн нэг элементийн өөрчлөлтийг харуулсан индекс бөгөөд үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрээр тооцсон индексийг ойлгоно.

Бүлгийн индекс – Нийлмэл үзэгдлийн элементүүдийн зарим нэг хэсгийг хамарсан индексийг ойлгоно.

Ерөнхий индекс – Нийлмэл үзэгдлийн бүх элементийн дундаж өөрчлөлтийг илэрхийлсэн индекс юм.

Жин – Нийт борлуулалтад тухайн бүтээгдэхүүний борлуулалтын эзлэх хувь хэмжээг жин гэнэ.

Сагс – Үнийн индекс тооцох зорилгоор сонгогдсон, индексийн тооцоонд төлөөлөх чадвартай, тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүний жагсаалтыг ойлгоно.


Суурь он – Үнийн индекс тооцоход суурь оныг зөв сонгох нь чухал байдаг. Суурь оныг сонгохдоо холбогдох бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт болон жинг тооцох боломжийг харгалзан үзнэ. Олон улсын туршлагаас харахад 5 жилийн давтамжтайгаар суурь оныг сонгодог.

Тайлант үе – Тухайн үйл ажиллагааны үр дүнг харуулсан тодорхой хугацааг ойлгоно. Тайлант үе нь сар, улирал, жил байна.

I. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС


Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс(2015=100) 2018 оны 12 дугаар сард 120.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 8.1 хувь, өмнөх сараас 8.5 хувиар буурсан байна.

Зураг 1. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, 2015=100, сараар, дэд салбараар, хувь



Аж үйлдвэрийн голлох салбар болох уул уурхай, олборлолтын дэд салбар нь ерөнхий индекст хүчтэй нөлөө үзүүлж байгаа нь дээрх графикаас харагдаж байна. Мөн ерөнхий индекс 2016 оны 1 дүгээр сараас 2018 оны 12 дугаар сар хүртэл аажмаар өссөн хандлагатай байна. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 2016 онд өмнөх оныхоос 37.8 хувь, 2017 онд 17.5 хувиар өсөж, 2018 онд 8.1 хувиар бууран, өсөлтийн хурдац 2017 оноос 25.6 пунктээр буурсан байна.

Зураг 2. Уул уурхай олборлолтын дэд салбарын үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, сараар, бүлгээр, хувь



Уул уурхай, олборлолтын дэд салбарын үнийн индекст металлын хүдэр олборлолтын үзүүлэх нөлөө нь бусад бүлгээсээ их байна. 2016 оны 8 дугаар сараас 2017 оны 1 дүгээр сар хүртэл уул уурхай, олборлолтын дэд бүлгийн индекс тогтмол өссөн байна.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, дэд салбараар, хувь

Бүлэг	2016	2017	2018
Ерөнхий индекс	137.8	117.5	91.9
Уул уурхай, олборлолт	151.2	120.4	89.0
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	95.6	163.5	95.2
Газрын тос, байгалийн хий олборлолт	252.0	112.3	89.1
Металлын хүдэр олборлолт	140.7	118.3	87.4
Бусад ашигт малтмал олборлолт	100.4	107.9	122.8
Уул уурхай, олборлолтын туслах бусад үйл ажиллагаа	100.0	99.5	97.0
Боловсруулах үйлдвэрлэл	103.3	104.6	109.7
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	99.0	102.6	108.0
Ундааны үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	99.6	101.6	112.3
Тамхины үйлдвэрлэл	107.2	107.7	102.2
Нэхмэлийн үйлдвэрлэл	110.0	109.7	130.9
Хувцас үйлдвэрлэл	100.2	100.5	100.1
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	100.1	99.9	120.7
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	99.9	101.1	101.4
Цаас болон цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	100.1	97.3	97.1

Хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	100.6	100.7	100.9
Кокс болон газрын тосны боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	100.0	100.7	117.5
Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	112.8	100.0	95.9
Эм, эм бэлдмэл, химийн болон ургамлын гаралтай эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	112.9	103.4	106.6
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл	100.0	119.7	100.9
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	104.4	102.6	96.8
Металл үйлдвэрлэл	110.9	122.8	106.6
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүний үйлдвэрлэл	100.0	102.1	105.6
Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл	124.3	97.9	105.2
Тавилга үйлдвэрлэл	100.0	100.0	96.3
Бусад боловсруулах үйлдвэрлэл	100.0	100.3	100.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	100.2	108.6	92.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	100.2	108.6	92.8
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	98.9	112.7	116.0
Ус цуглуулах, ариутгах, ус хангамж	98.6	116.2	119.9
Хог хаягдлыг цуглуулах, ариутгах, боловсруулах үйл ажиллагаа	100.0	100.0	100.0
Хог хаягдлын менежментийн болон бусад цэвэрлэх үйл ажиллагаа	100.0	100.0	100.0

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс нь уул уурхай, олборлолтын дэд салбараас нэлээдгүй хамааралтай байгаа нь харагдаж байна. Аж үйлдвэрийн үйлдвэрлэгчийн үнийн индекс 2018 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар буурахад уул уурхай, олборлолтын дэд бүлгийн индекс 11.0 хувиар (чулуун, хүрэн нүүрс олборлолтынх 4.8 хувь, газрын тос, байгалийн хий олборлолтынх 10.9 хувь) буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 3. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийн дэд салбаруудын оролцооны түвшин, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



2017 онд аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексд уул уурхай, олборлолтын дэд бүлгийн нөлөө 16.3 нэгж байсан бол 2018 онд тус бүлэг (-9.0) нэгж болж 25.3 пунктээр буурсан байна. Харин боловсруулах үйлдвэрлэлийн дэд бүлгийн нөлөө 2017 онд 0.6 нэгж байсан бол 2018 онд 1.2 нэгж болж 0.6 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийн дэд салбаруудын оролцооны түвшин, хувь


Бүлэг	2016		2017		2018	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	37.8	100.0	17.5	100.0	-8.1	100.0
Уул уурхай, олборлолт	37.2	98.4	16.3	93.0	-9.0	110.8
Боловсруулах үйлдвэрлэл	0.6	1.6	0.6	3.6	1.2	-14.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.0	0.0	0.5	3.0	-0.4	4.9
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.0	0.0	0.1	0.5	0.1	-1.3

Зураг 4. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, өмнөх сартай харьцуулснаар, дэд салбараар, хувь, 2018 он



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 2018 оны 12 сард өмнөх сараас 8.5 хувиар буурсан байна. Динамикаас харахад 5 дугаар сард үнийн индекс нэлээн өсөлттэй байдаг нь харагдаж байна.

Зураг 5. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн өсөлт, хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, 2018 он



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийг аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтэй 2018 оны саруудаар харьцуулж харвал ихэнх сард хандлага нь адилхан байна.

ХАВСРАЛТ 1

Хугацаа	Ерөнхий индекс	Дэд салбараар				
		Уул уурхай, олборлолт	Боловсруулах үйлдвэрлэл	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	
2015=100		өмнөх оны мөн үетэй харьцуулснаар				
2016	I	77.3	71.0	100.4	98.2	98.9
	II	86.2	82.4	100.4	99.2	98.9
	III	83.7	79.0	100.6	101.9	98.9
	IV	85.0	80.7	100.7	101.3	98.9
	V	93.8	91.9	101.3	99.8	98.9
	VI	82.3	77.6	101.5	102.6	98.9
	VII	83.2	78.5	101.8	102.2	98.9
	VIII	100.0	99.4	101.9	103.9	98.9
	IX	113.3	116.7	101.9	102.9	98.9
	X	116.8	121.7	102.0	102.5	98.9
	XI	126.4	134.8	102.8	102.1	98.9
	XII	137.8	151.2	103.3	100.2	98.9
2017	I	157.6	178.0	104.7	108.4	112.7
	II	141.5	153.4	104.9	106.6	112.7
	III	144.5	158.0	104.8	106.9	112.7
	IV	135.5	145.6	104.7	106.2	112.7
	V	133.5	141.6	104.2	109.7	112.7
	VI	119.8	124.2	104.4	109.2	112.7
	VII	134.8	144.3	103.7	110.1	112.7
	VIII	122.0	126.6	104.1	108.0	112.7
	IX	125.8	131.0	105.2	109.0	112.7
	X	123.9	128.7	105.6	108.4	112.7
	XI	111.8	113.4	104.4	108.6	112.7
	XII	117.5	120.4	104.6	108.6	112.7
2018	I	106.5	107.4	103.4	102.6	96.8
	II	105.1	105.3	104.4	103.5	100.0
	III	107.5	108.8	105.4	95.0	99.1
	IV	106.8	108.3	105.1	91.6	99.1
	V	102.6	102.9	105.8	90.6	115.9
	VI	127.4	133.8	106.1	97.3	116.0
	VII	110.7	111.6	107.5	105.1	116.0
	VIII	107.4	107.5	106.9	106.3	116.0
	IX	102.5	102.2	108.4	93.5	116.0
	X	109.2	110.0	108.4	99.9	116.0
	XI	108.6	109.6	109.3	94.1	116.0
	XII	91.9	89.0	109.7	92.8	116.0

Хугацаа	Ерөнхий индекс	Дэд салбараар				
		Уул уурхай, олборлолт	Боловсруулах үйлдвэрлэл	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	
2015=100						
өмнөх оны эцэстэй харьцуулснаар						
2016	I	95.8	94.3	100.4	98.3	98.9
	II	109.2	112.7	100.4	99.2	98.9
	III	106.3	108.3	100.6	101.9	98.9
	IV	108.9	111.9	100.7	101.4	98.9
	V	120.2	127.5	101.3	99.8	98.9
	VI	115.2	120.2	101.5	102.7	98.9
	VII	112.1	116.0	101.8	102.2	98.9
	VIII	126.3	135.4	101.9	103.9	98.9
	IX	130.3	140.8	101.9	102.9	98.9
	X	127.8	137.4	102.0	102.5	98.9
	XI	133.8	145.6	102.8	102.1	98.9
	XII	137.8	151.2	103.3	100.2	98.9
2017	I	109.5	111.0	101.8	106.3	112.7
	II	112.1	114.3	102.0	105.5	112.7
	III	111.5	113.2	102.1	108.7	112.7
	IV	107.0	107.8	102.1	107.5	112.7
	V	116.4	119.4	102.2	109.3	112.7
	VI	100.2	98.7	102.6	111.9	112.7
	VII	109.6	110.7	102.2	112.3	112.7
	VIII	111.8	113.3	102.7	111.9	112.7
	IX	118.9	122.0	103.8	111.9	112.7
	X	114.9	117.0	104.3	110.9	112.7
	XI	108.6	109.2	103.8	110.6	112.7
	XII	117.5	120.4	104.6	108.6	112.7
2018	I	99.3	99.1	100.6	100.5	96.8
	II	100.3	100.0	92.6	100.6	100.0
	III	102.0	102.3	102.9	95.1	99.1
	IV	97.3	97.0	102.6	90.7	99.1
	V	101.7	102.0	103.3	91.2	115.9
	VI	108.6	109.8	104.1	100.4	116.0
	VII	103.3	102.6	105.0	108.7	116.0
	VIII	102.2	101.2	104.9	109.7	116.0
	IX	103.7	103.6	107.5	96.4	116.0
	X	106.8	106.9	108.0	102.0	116.0
	XI	100.4	99.4	108.5	95.9	116.0
	XII	91.9	89.0	109.7	92.8	116.0

Хугацаа	Ерөнхий индекс	Дэд салбараар				
		Уул уурхай, олборлолт	Боловсруулах үйлдвэрлэл	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	
2015=100						
өмнөх сартай харьцуулснаар						
2016	I	95.8	94.3	100.4	98.3	98.9
	II	114.0	119.5	99.9	101.0	100.0
	III	97.3	96.1	100.3	102.7	100.0
	IV	102.4	103.3	100.1	99.5	100.0
	V	110.4	114.0	100.5	98.5	100.0
	VI	95.8	94.3	100.2	102.9	100.0
	VII	97.3	96.5	100.3	99.5	100.0
	VIII	112.7	116.7	100.1	101.6	100.0
	IX	103.1	104.1	100.1	99.1	100.0
	X	98.1	97.6	100.1	99.7	100.0
	XI	104.7	106.0	100.7	99.6	100.0
	XII	103.0	103.8	100.5	98.1	100.0
2017	I	109.5	111.0	101.8	106.3	112.7
	II	102.4	103.0	100.2	99.3	100.0
	III	99.4	99.0	100.2	103.0	100.0
	IV	96.0	95.2	100.0	98.9	100.0
	V	108.8	110.8	100.0	101.7	100.0
	VI	86.0	82.7	100.4	102.4	100.0
	VII	109.5	112.1	99.6	100.3	100.0
	VIII	102.0	102.4	100.5	99.7	100.0
	IX	106.3	107.7	101.1	99.9	100.0
	X	96.6	95.9	100.5	99.2	100.0
	XI	94.5	93.3	99.6	99.7	100.0
	XII	108.2	110.2	100.8	98.1	100.0
2018	I	99.3	99.1	100.6	100.5	96.8
	II	101.0	101.0	93.2	100.2	103.3
	III	101.7	102.3	101.1	94.5	99.1
	IV	95.4	94.7	99.7	95.4	100.0
	V	104.5	105.2	100.6	100.6	116.9
	VI	106.8	107.6	100.8	110.0	100.1
	VII	95.1	93.4	100.9	108.4	100.0
	VIII	99.0	98.7	99.9	100.8	100.0
	IX	101.4	102.3	102.5	87.9	100.0
	X	103.0	103.2	100.5	105.9	100.0
	XI	94.0	93.0	100.4	94.0	100.0
	XII	91.5	89.5	101.2	96.8	100.0

Тооцооны арга зүй

ҮҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангаж байх үүднээс сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчлэн тооцож байхыг олон улсын байгууллагаас зөвлөмж болгосон байдаг. Нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтөөс үүдэн ААНБ-ын үйлдвэрлэл, үйлчилгээний бүтцэд өөрчлөлт орох, хэрэглэгчийн орлогын өөрчлөлтөөс шалтгаалан хэрэглээний бүтэц өөрчлөгдөх зэргээс шалтгаалан үйлдвэрлэгчийн үнийн суурь, сагс, жинг шинэчлэх шаардлага бий болдог. Мөн түүнчлэн үндэсний тооцооны тооцооллын суурь үеийг 5 жил тутам шинэчилж, салбарын үйлвэрлэгчийн үнийг дефлятор болгон ашигладаг.

Сагс бүрдүүлэлт – Аж үйлдвэрийн салбарын онцлогоос хамааруулан бүтээгдэхүүн нь сүүлийн 3 жилийн турш зах зээлд тогтмол нийлүүлэгдэж буй, ижил төрлийн бүтээгдэхүүнээр төлөөлж болохуйц, цаашид судлагдах боломжтой гэсэн нөхцлийг харгалзан үзэж, нийт борлуулалтын орлогод 70-аас доошгүй хувийг эзлэж буй бүтээгдэхүүнийг сонгох зарчмыг баримталдаг.

Жин тооцох – Суурь судалгаагаар цуглуулсан аж үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын мэдээллийг жин тооцоход ашиглана. Индексийн тооцоонд ашиглагдах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын орлогод эзлэж буй хувийн жингээр тодорхойлно. Жин нь тухайн салбарын нийт бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын орлогод эзлэх жин байна. Иймд сонгогдоогүй бүтээгдэхүүн, үйлчилгээний жинг ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээний жинд шингээж, жин 1.0-тэй тэнцүү байна.

Салбарын бүтцэд гарч байгаа өөрчлөлт болон үнийн өөрчлөлтийг харгалзан бүтээгдэхүүний жинг 3-5 жил тутамд шинэчилнэ.

Хүснэгт 3. Аж үйлдвэрийн салбарын жин, дэд салбараар

Дэд салбар	2015 он
Нийт жин	100.0
Уул уурхай, олборлолт	77.9
Боловсруулах үйлдвэрлэл	14.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6.7
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.8

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийг салбартаа тэргүүлэгч 186 аж ахуйн нэгж байгууллагын 1089 бүтээгдэхүүний үнийг сар бүр судлан, индекс тооцож бюллетень болон цахим хэлбэрээр нийтэд тархааж байна. Аж үйлдвэрийн салбарыг төлөөлж 2015 оны суурь судалгаанд сонгогдсон нийт ААНБ-ын 77.9 хувийг уул уурхай, олборлолтын дэд салбар, 14.6 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн дэд салбар, 6.7 хувийг цахилгаан, хий, уур, агааржуулалтын дэд салбар, 0.8 хувийг ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны дэд салбар бүрдүүлж байна.